

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2021 оны 8 дугаар сарын 11 -ний өдөр

1. “Монголросцветмет” ТӨҮГ нь Хэнтий аймгийн Дархан сумын нутагт орших XV-021822 тоот Баргилт нэртэй талбайд хийгдэх геологи хайгуулын өрөмдлөгийн ажил гүйцэтгэх, үр дүнгийн тайлан боловсруулж ЭБМЗ-д хамгаалах зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. **Энэхүү зөвлөх үйлчилгээ хийж гүйцэтгэснээр нь** ТӨҮГ-ын харьяа “Бор-Өндөр” УБҮ-ийн хайлуур жоншны нөөцийг нэмэгдүүлэх, үйлдвэрийн бүтээмжийг өсгөх болно.
3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх хуулийн этгээд нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:
 - Байгууллагын ерөнхий танилцуулга
 - Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн/
 - Татвар, нийгмийн даатгалын газар, ШШГЕГ болон банкны тодорхойлолт зэргийг тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар/ ирүүлнэ.
 - Чадварыг нэмэгдүүлж, сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.
 - Сүүлийн 2 жил (2019, 2020 он) ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт эсвэл өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт.
4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2021 оны 8 дугаар сарын 14–ны өдрийн 09 цагаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгийг 2021 оны 8 дугаар сарын 17– ны өдрийн 09 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар ирүүлнэ.

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ